



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/22/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор Г.Золбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: ZolbayarG@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2025 он

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/22/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитор: Г.Золбаяр Утас: 70373089 Цахим хаяг: zolbayarg@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
1.1 Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг	
1.2 Аудитын гол асуудал	
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	132
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	132
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	165
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	165
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	175
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	177
5.2 Албан шаардлага	187
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ,ЗДНХөрөнгө	Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 49

танай _____-ны № _____-т

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА М.ХУВЬЗАЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2024 оны 06 сарын 26-ны өдрийн 01-А/293 тоот захирамжийн дагуу 1,400 м.кв талбайтай газар эзэмших хугацааг 15 жилээр сунгаж гэрээ байгуулан, 23,520.0 мянган төгрөгөөр биет бус хөрөнгөөр бүртгэж, санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4525020127

Тайлант онд урсгал үйл ажиллагаанаас гадна 275,625.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, ажилчдын орон нутгийн нэмэгдэл цалин болон нийгмийн даатгалын шимтгэлд нийт 180,331.9 мянган төгрөг, УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн зардалд 95,293.1 мянган төгрөг зарцуулсан байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан-Уул аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай байгуулсан 2024 оны 01 сарын 05-ны өдрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 43 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 89.3 хувиар дүгнүүлэн 21 аймаг 9 дүүргээс 13 дугаар байранд эрэмбэлэгдэн ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	27,544,986.23	24,501,908.79
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	11,644,864.23	1,955,142.79
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,279,641.23	1,955,142.79
3121	Төгрөг	6,279,641.23	1,955,142.79
31211	Төрийн сангийн харилцах	4,013,133.91	1,937,142.79
31212	Монгол банкин дахь харилцах	-	-
31213	Арилжааны банк дахь харилцах	2,266,507.32	18,000.00
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	5,365,223.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	15,900,122.00	22,546,766.00
351	Түүхий эд материал	7,410,042.00	15,025,786.00
35110	Тусгай зориулалттай материал	7,410,042.00	15,025,786.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,613,170.00	3,613,170.00
354	Хангамжийн материал	4,876,910.00	3,907,810.00
35410	Бичиг хэргийн материал	-	-
35420	Аж ахуйн материал	1,937,810.00	1,937,810.00
35430	Сэлбэг хэрэгсэл	289,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	2,650,100.00	1,970,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	203,992,955.28	206,319,178.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	203,992,955.28	206,319,178.28
391	Газар	-	-
392	Биет хөрөнгө	203,992,955.28	182,799,178.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	98,454,296.80	98,454,296.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	(11,720,749.80)	(14,064,899.76)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	58,000,000.00	58,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(58,000,000.00)	(58,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	168,646,112.39	188,176,442.39
39206	Хуримтлагдсан элэгдэл	(60,897,204.16)	(97,645,161.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,318,000.00	41,318,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,807,499.95)	(33,439,499.95)
393	Биет бус хөрөнгө	-	23,520,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	23,520,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	231,537,941.51	230,821,087.07
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,631,730.32	18,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,631,730.32	18,000.00
414	Урьдчилж орсон орлого	7,631,730.32	18,000.00
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	7,631,730.32	18,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	223,906,211.19	230,803,087.07
51	Засгийн газрын хувь оролцоо	223,906,211.19	230,803,087.07
51101	Өмч: - төрийн	-	23,520,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	153,879,156.08	137,256,031.96
51210	Өмнөх үеийн үр дүн	153,879,156.08	153,879,156.08
51220	Тайлант үеийн үр дүн	-	(16,623,124.12)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	70,027,055.11	70,027,055.11
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-	-
51600	Нөөцийн сан	-	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	231,537,941.51	230,821,087.07

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	880,764,076.02	1,464,207,660.88
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	97,345,476.02	51,721,310.88
120	Нийтлэг татварын бус орлого	97,345,476.02	51,721,310.88
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,777,965.00	41,104,520.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		10,616,790.88
120005	Түрээсийн орлого	-	-
120006	Газрын тосны орлого	-	-
120007	Навигацийн орлого	-	-
120008	Монгол банкны ашиг	-	-
120009	Бусад орлого	4,013,133.91	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	783,418,600.00	1,412,486,350.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	783,418,600.00	1,136,861,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	716,620,700.00	1,136,861,300.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	66,797,900.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	275,625,050.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	180,331,950.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	95,293,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	852,614,829.15	1,480,830,785.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	852,614,829.15	1,480,830,785.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	850,784,825.99	1,357,413,184.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	612,598,422.00	1,017,605,294.55
210101	Үндсэн цалин	390,643,615.76	536,050,558.47
210102	Нэмэгдэл	162,740,359.60	383,351,050.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,771,662.64	78,555,185.83
210104	Урамшуулал	17,442,784.00	19,648,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,319,778.00	121,290,355.45
210201	Тэтгэврийн даатгал	78,927,678.00	90,757,755.45
210202	Тэтгэмжийн даатгал	8,773,000.00	7,139,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,898,400.00	3,898,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	974,600.00	3,898,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,746,100.00	15,595,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,020,000.00	34,020,000.00
210304	Байрны түрээс	34,020,000.00	34,020,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,382,784.84	15,863,568.12
210401	Бичиг хэрэг	11,654,133.83	10,913,250.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,450,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,747,951.01	2,063,588.12
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,480,700.00	1,436,730.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,628,000.00	2,481,650.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,111,000.00	1,710,650.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,517,000.00	210,000.00
210604	Урсгал засвар	-	561,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	814,500.00
210702	Дотоод албан томилолт	-	814,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,539,762.00	29,812,666.00

Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,751,312.00	1,406,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	98,010.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,000,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	21,788,450.00	28,307,756.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,296,079.15	135,525,150.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,733,800.00	101,697,254.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	970,000.00	946,128.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,592,279.15	32,881,767.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,830,003.16	123,417,600.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,066,000.00	123,417,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	121,573,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,066,000.00	1,844,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	764,003.16	0.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	764,003.16	0.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>28,149,246.87</u>	<u>(16,623,124.12)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	19,256,000.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(19,256,000.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>8,893,246.87</u>	<u>(16,623,124.12)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,243,454,604.42	1,868,546,831.55
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	460,036,004.42	456,060,481.55
120	Нийтлэг татварын бус орлого	460,036,004.42	456,060,481.55
120003	Торгуулийн орлого	456,022,870.51	455,877,672.67
120009	Бусад орлого	4,013,133.91	182,808.88
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	783,418,600.00	1,412,486,350.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	783,418,600.00	1,136,861,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	716,620,700.00	1,136,861,300.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	66,797,900.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	275,625,050.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	180,331,950.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	95,293,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,242,355,407.30	1,877,165,352.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,242,355,407.30	1,877,165,352.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	781,588,596.84	1,290,256,349.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	612,585,822.00	1,015,730,376.00
210101	Үндсэн цалин	390,988,798.35	524,698,426.54
210102	Нэмэгдэл	162,382,577.01	392,828,263.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,771,662.64	78,555,185.83
210104	Урамшуулал	17,442,784.00	19,648,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,319,778.00	123,165,274.00
210201	Тэтгэврийн даатгал	78,927,678.00	91,974,374.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,773,000.00	7,797,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,898,400.00	3,898,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	974,600.00	3,898,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,746,100.00	15,595,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,020,000.00	34,200,000.00
210304	Байрны түрээс	34,020,000.00	34,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,234,996.84	14,796,900.00
210401	Бичиг хэрэг	11,691,865.83	10,037,263.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,450,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,615,731.01	2,063,588.12
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	818.88
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,427,400.00	1,245,230.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,707,000.00	1,888,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,109,000.00	1,275,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,521,000.00	193,600.00
210604	Урсгал засвар	77,000.00	420,000.00
2107	Томиллолт, зочны зардал	-	814,500.00
210702	Дотоод албан томиллолт	-	814,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,721,000.00	1,238,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,721,000.00	1,138,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,000,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	98,421,899.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	97,551,899.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	870,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	460,766,810.46	586,909,003.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,066,000.00	123,417,600.00

Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	121,573,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,066,000.00	1,844,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	409,554,394.50	426,424,576.63
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	764,003.16	0.80
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	50,146,415.96	37,066,827.16
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,146,415.96	37,066,827.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,099,197.12</u>	<u>(8,618,521.44)</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	1,071,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,071,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,071,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	1,071,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(1,071,200.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,099,197.12	(9,689,721.44)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,545,667.11	11,644,864.23
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,644,864.23	1,955,142.79

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл		70,027,055.11	144,985,909.21	215,012,964.32
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		-	-	-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз		-	-	-
7	Тайлант үеийн үр дүн		-	8,893,246.87	8,893,246.87
8	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		70,027,055.11	153,879,156.08	223,906,211.19
9	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		70,027,055.11	153,879,156.08	223,906,211.19
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-	-	-
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			-	-
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-	-	-
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	23,520,000.00	-	-	23,520,000.00
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз		-	-	-
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-	-	-
16	Тайлант үеийн үр дүн		-	(16,623,124.12)	(16,623,124.12)
17	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	23,520,000.00	70,027,055.11	137,256,031.96	230,803,087.07

Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,136,861,300.00	1,136,861,300.00	-	100%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,136,861,300.00	1,136,861,300.00	-	100%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,013,443,700.00	1,013,443,700.00	-	100%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	855,058,400.00	855,058,400.00	-	100%
210101	Үндсэн цалин	490,040,000.00	524,698,426.54	34,658,426.54	100%
210102	Нэмэгдэл	258,538,400.00	232,156,287.63	(26,382,112.37)	107%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	95,700,000.00	78,555,185.83	(17,144,814.17)	90%
210104	Урамшуулал	10,780,000.00	19,648,500.00	8,868,500.00	82%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,505,300.00	103,505,300.00	-	182%
210201	Тэтгэврийн даатгал	72,314,400.00	72,314,400.00	-	100%
210202	Тэтгэмжийн даатгал	7,797,700.00	7,797,700.00	-	100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,898,900.00	3,898,900.00	-	100%
210204	Ажилгүйдлийн даатгал	3,898,900.00	3,898,900.00	-	100%
210205	Эрүүл мэндийн даатгал	15,595,400.00	15,595,400.00	-	100%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,200,000.00	34,200,000.00	-	100%
210304	Байрны түрээс	34,200,000.00	34,200,000.00	-	100%
2104	Хангамж, бараа материалын зардал	14,931,900.00	14,931,900.00	-	100%
210401	Бичиг хэрэг	10,380,000.00	10,037,263.00	(342,737.00)	100%
210402	Тээвэр, шатахуун	1,450,000.00	1,450,000.00	-	97%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	2,063,588.12	563,588.12	100%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,900.00	818.88	(11,081.12)	138%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,590,000.00	1,380,230.00	(209,770.00)	7%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,513,600.00	2,513,600.00	-	87%
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,740,000.00	1,740,000.00	-	100%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	193,600.00	193,600.00	-	100%
210604	Урсгал засвар	580,000.00	580,000.00	-	100%
2107	Томилолт, зочны зардал	814,500.00	814,500.00	-	100%
210702	Дотоод албан томилолт	814,500.00	814,500.00	-	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,550,000.00	1,550,000.00	-	100%

Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,450,000.00	1,450,000.00	-	100%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	100,000.00	-	100%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	870,000.00	870,000.00	-	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	870,000.00	870,000.00	-	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	123,417,600.00	123,417,600.00	-	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг	123,417,600.00	123,417,600.00	-	100%
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	121,573,600.00	121,573,600.00	-	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,844,000.00	1,844,000.00	-	100%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,136,861,300.00	1,136,861,300.00	-	100%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,136,861,300.00	1,136,861,300.00	-	100%
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,136,861,300.00	1,136,861,300.00	-	100%
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	29	29	-	
620001	Удирдах ажилтан	1	1	-	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	26	26	-	100%
620004	Гэрээт ажилтан	2	2	-	100%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	29	29	-	100%
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	22	22	-	100%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	-	100%
650010	Гэрээт ажилтан	2	2	-	100%
				-	100%

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	275,625,050.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	275,625,050.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	275,625,050.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	160,671,976.00
210101	Үндсэн цалин	-
210102	Нэмэгдэл	160,671,976.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,659,974.00
210201	Тэтгэврийн даатгал	19,659,974.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	95,293,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	95,293,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	275,625,050.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	180,331,950.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	95,293,100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь иргэний бүртгэлийн тасаг болон эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасаг 2 нэгжтэйгээр, төрийн захиргааны 22, төрийн үйлчилгээний 5, гэрээт 2, нийт 29 албан хаагчтайгаар тайлант онд 7 зорилт 43 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн ба иргэн, хуулийн этгээдэд хуулийн дагуу төрийн бүртгэлийн цогц үйлчилгээг үзүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаал зэргийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөж байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох

Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 230,821.1 мянган төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,279.6	1,955.1	4,324.5
Авлага	-	-	-
Бараа материал	15,900.1	22,546.7	6,646.6
Үндсэн хөрөнгө	203,992.9	206,319.1	2,326.2
Нийт хөрөнгө	231,537.9	230,821.1	(716.8)
Өр төлбөр	7,631.7	18.0	(7,613.7)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	223,906.2	230,803.1	6,896.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	231,537.9	230,821.1	(716.8)

Мөнгөн хөрөнгийн 1,955.1 мянган төгрөгийн үлдэгдэл нь ахмадын санд төвлөрүүлсэн хөрөнгийн үлдэгдэл байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 6,646.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд аж ахуйн материал болон бусад хангамжийн бараа материалын үлдэгдэлтэй холбоотой байна. Бараа материал дансны үлдэгдэлд тусгай зориулалтын материал буюу үнэт цаасны агууламжтай бүх төрлийн бүртгэл лавлааны бэлдэц 66.6% эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн өсөлт нь биет бус хөрөнгө болох 23,520.0 мянган төгрөгийн газрыг Дархан-Уул аймгийн Засаг даргын 2024 оны 06 сарын 26-ны өдрийн 01-А/293 тоот захирамжийн дагуу нэмж бүртгэсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүнрүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй бөгөөд газрыг бүртгэлд авсан 23,520.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн үр дүн 16,623.1 мянган төгрөгөөр буурчээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 1,138,861.3 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн ба тухайн төсвийн төслийг хэвээр баталсан байна. Өмнөх жилийн санхүүжилтээс өссөн нь төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэн, мөн 5 жил тогтвортой ажилласны урамшуулал олгосонтой холбоотой.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 7 зорилт хөтөлбөрийн 43 арга хэмжээг санхүүжүүлэх 1,138,861.3 мянган төгрөгийг 100 хувь улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,138,861.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг урсгал үйл ажиллагаанд бүрэн зарцуулж, өөрийн орлого буюу иргэний болон эд хөрөнгийн бүртгэлийн бүх төрлийн лавлагаа үйлчилгээнээс төвлөрсөн 456,060.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,138,861.3 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувиар/
1	70406- Улсын бүртгэл мэдээлэл	1,136,861.3	1,136,861.3	-	100
1.1	210 - Үндсэн үйл ажиллагааны зардал	1,013,443.7	1,013,443.7	-	100
1.2	213 - Бусад урсгал шилжүүлэг	123,417.6	123,417.6	-	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тайлант онд ахмадын сангийн эхний үлдэгдэл 4,013.1 мянган төгрөг дээр 182.8 мянган төгрөг нэмж төвлөрүүлснээр 3 ахмадад цагаан сар болон ахмадын баяраар нийт 2,258.8 мянган төгрөг зарцуулж тус сангийн үлдэгдэл 1,937.1 мянган төгрөг болсон байна. Албан хаагчийн хувьд батлагдсан орон тоогоор буюу төрийн захиргааны 22, төрийн үйлчилгээний мэргэжлийн 5, гэрээт 2 нийт 29 ажилтантай үйл ажиллагаагаа явуулсан байна. Худалдан авах ажиллагааны зардалд нийт 2,320.0 мянган төгрөг төсөвлөж гүйцэтгэлээр 100% бүрэн зарцуулсан бөгөөд тус зардалд өдөр тутмын үйл ажиллагаанд зарцуулах принтерийн хор авах, цэнэглэх, бал, архивийн хавтас зэрэг материалууд багтсан.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр орон нутгаас 275,625.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл цалинд 160,671.9 мянга, нийгмийн даатгалын шимтгэлд 19,659.9 мянган төгрөг, УИХ-ын сонгууль болон орон нутгийн сонгуультай холбоотой 95,293.1 мянган төгрөгийг тус тус зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Золбаяр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дугаар сарын 24-ний өдрийн 17/64 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны анхны батлагдсан төсвөөр 1,724,152.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 17,241.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,400,251.6 мянган төгрөгийн 31 орлогын гүйлгээ, 667,326.2 мянган төгрөгийн 22 зардлын гүйлгээг хуулийн хугацаанд нь мэдээлжээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 01/562 тоот албан бичгээр ирүүлснийг шалгахад 100 хувь хэрэгжсэн байлаа.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	-	3	-	100%
Нийт дүн	3	-	3	-	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 177,399.1 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлж аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Өмчийн өөрчлөлтийн тайланд хуримтлагдсан үр дүнгийн эхний үлдэгдэл 153,879.1 мянган төгрөгийг тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн тодруулга”, “Толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул аудитын явцад дээрх дүнгээр өмчийн өөрчлөлтийн тайланд бүртгэж залруулав.
- Тайлант онд 23,520.0 мянган төгрөгийн газрыг орлогод авахдаа үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн тодруулга”, “Толилуулга”, “иж бүрэн байх”, “Ангилал” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул орлогод авсан дүнгээр биет бус хөрөнгийг нэмэгдүүлж залруулав гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул аудитын явцад залруулав.

¹ Мэдээллийг тусгаагүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд байгууллагын албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдэл цалинг 20 хувиар хэтрүүлэн нийт 7,062.8 мянган төгрөг илүү олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”*, 16 дугаар зүйлийн 16.5.5-д *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т *“Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”* заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Санхүүгийн тайлагналтай холбоотой зөвлөмж өгөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмчийн өөрчлөлтийн тайланд хуримтлагдсан үр дүнгийн эхний үлдэгдлийг тусгаагүй.	1	153,879.1	1	153,879.1	-	-	1	153,879.1	-	-	-	-
Газрыг орлогод авахдаа үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн.	1	23,520.0	-	-	1	23,520.0	1	23,520.0	-	-	-	-
Дүн	2	177,399.1	1	13.9	1	290,666.3	2	177,399.1	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орон нутагт ажилласны нэмэгдэл цалинг 24 албан хаагчид илүү олгосон.	1	7,062.8	1	7,062.8	-	-	-	-	-	-	-	-
Дүн	1	7,062.8	1	7,062.8	-	-	-	-	-	-	-	-